



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянлиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/101/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баянхонгор хот

2024 оны 02 дугаар сар 20

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа

Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК

Захирал Г.Саранчимэг

Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Аудитор: О.Мандах

Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /Төгрөгөөр/.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/	10
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18
Өмнөх оны аудитаар зөвлөмжийн хэрэгжүүлээгүй, 1,050.0 малыг нас дэвшилт хийж бүртгээгүй, тооллогын комисс малыг нүд үзэж тоолоогүй байхад актлах шийдвэр гаргаж данснаас хассан.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/47
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянлиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянлиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 71802 хөтөлбөрийн 12 арга хэмжээний зардалд 2,336,913.7 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 2,112,471.1 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт 5,970.5 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 335,287.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Аудитаар цахим хэрэглээний зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй, үдийн хоолны материалын

5020190

үлдэгдэл ихтэй байгаа зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс бага байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баянлиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 99.4 хувьтай тайлагнаж дээд шатны байгууллагаас 88,1 хувьтай дүгнэсэн байна.

Баянлиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>186,951,584.67</u>	<u>485,332,095.98</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	38,067,514.86	335,287,404.49
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	38,067,514.86	335,287,404.49
3121	Төгрөг	38,067,514.86	335,287,404.49
31211	Төрийн сангийн харилцах	38,067,514.86	335,287,404.49
33	АВЛАГА	23,701,800.00	00.00
335	Бусад авлага	23,701,800.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	23,701,800.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	125,182,269.81	150,044,691.49
351	Түүхий эд материал	22,855,416.78	41,956,832.46
35110	Тусгай зориулалттай материал	21,521,016.78	41,630,432.46
35130	Эм боох материал	1,334,400.00	326,400.00
354	Хангамжийн материал	101,276,853.03	108,087,859.03
35410	Бичиг хэргийн материал	984,110.00	779,110.00
35420	Аж ахуйн материал	100,292,743.03	104,323,749.03
35450	Барилгын засварын материал	00.00	2,985,000.00
35600	Мал амьтад	1,050,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,267,553,789.65</u>	<u>5,222,411,095.42</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,267,553,789.65	5,222,411,095.42
392	Биет хөрөнгө	5,219,583,789.65	5,174,441,095.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,714,792,117.02	5,714,792,117.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	-764,573,646.23	-871,644,957.05
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,500,000.00	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,500,000.00	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	408,304,017.14	487,847,747.14
39206	Хуримтлагдсан элэгдэл	-251,307,539.58	-259,273,220.13
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	236,855,411.20	257,383,177.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-151,002,622.90	-154,663,768.76
39217	Ном	26,516,053.00	00.00
393	Биет бус хөрөнгө	47,970,000.00	47,970,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	47,970,000.00	47,970,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,454,505,374.32</u>	<u>5,707,743,191.40</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,454,505,374.32</u>	<u>5,707,743,191.40</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,454,505,374.32	5,707,743,191.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	514,828,217.20	514,828,217.20
51101	Өмч: - төрийн	514,828,217.20	514,828,217.20
512	Хуримтлагдсан үр дүн	4,288,721,693.43	4,541,959,510.51
51210	Өмнөх үеийн үр дүн	4,288,721,693.43	4,288,721,693.43
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	253,237,817.08

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	650,955,463.69	650,955,463.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,454,505,374.32	5,707,743,191.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,688,250,559.24	2,555,205,139.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	911,509,425.24	275,085,339.96
120	Нийтлэг татварын бус орлого	911,509,425.24	275,085,339.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	904,899,465.00	234,472,992.28
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,985,700.00	135,541,798.28
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,471,825.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/ҮХ/	897,441,940.00	98,931,194.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/БМ/	6,609,960.24	40,612,347.68
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	367,018,834.00	2,280,119,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,944,063,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,944,063,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,409,722,300.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,189,134.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,189,134.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	323,829,700.00	336,056,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	323,829,700.00	336,056,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,924,290,894.26	2,275,259,082.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,924,290,894.26	2,275,259,082.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,791,887,566.14	2,139,823,270.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,021,125,046.15	1,259,249,499.17
210101	Үндсэн цалин	703,396,458.15	836,811,433.44
210102	Нэмэгдэл	245,028,512.00	360,766,051.82
210104	Урамшуулал	36,915,741.00	61,672,013.91
210105	Гэрээт ажлын хөлс	35,784,335.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,513,434.60	158,228,056.46
210201	Тэтгэврийн даатгал	86,814,277.92	109,642,356.46
210202	Тэтгэмжийн даатгал	9,668,739.00	12,146,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,704,300.00	9,717,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,926,200.00	2,429,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,399,917.68	24,292,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	260,588,332.79	313,086,162.31
210301	Гэрэл, цахилгаан	10,299,832.79	12,739,962.31
210302	Түлш, халаалт	250,288,500.00	300,346,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,465,274.20	65,399,571.50

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	298,000.00	20,017,915.00
210402	Тээвэр, шатахуун	6,180,074.20	5,339,330.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	250,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,747,200.00	6,392,700.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	33,399,626.00
2105	Нормативт зардал	95,011,490.00	105,564,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,244,240.00	1,476,400.00
210502	Хоол, хүнс	90,767,250.00	104,087,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,567,000.00	14,015,000.00
210604	Урсгал засвар	3,567,000.00	14,015,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,370,200.00	2,209,000.00
210702	Дотоод албан томилолт	1,370,200.00	2,209,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,816,500.00	17,720,633.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,271,500.00	6,788,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	800,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,045,000.00	10,132,333.52
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	260,430,288.40	204,351,047.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,100,000.00	8,778,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,154,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	237,176,288.40	195,573,047.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	132,403,328.12	135,435,811.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	113,047,434.00	129,465,274.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	69,858,300.00	84,432,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	43,189,134.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	45,033,274.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,355,894.12	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	5,970,537.69
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,970,537.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>763,959,664.98</u>	<u>279,946,057.58</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	26,708,240.50
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	26,708,240.50
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-26,708,240.50
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>763,959,664.98</u>	<u>253,237,817.08</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,784,287,390.72	2,415,661,598.28

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,546,256.72	135,541,798.28
120	Нийтлэг татварын бус орлого	7,546,256.72	135,541,798.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,546,256.72	135,541,798.28
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,074,431.72	135,541,798.28
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,471,825.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,776,741,134.00	2,280,119,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,944,063,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,944,063,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,409,722,300.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,189,134.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,189,134.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	323,829,700.00	336,056,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	323,829,700.00	336,056,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,717,997,765.86	2,060,464,308.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,717,997,765.86	2,060,464,308.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,568,907,237.74	1,925,028,496.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,021,125,046.15	1,259,249,499.17
210101	Үндсэн цалин	703,396,458.15	836,811,433.44
210102	Нэмэгдэл	245,028,512.00	360,766,051.82
210104	Урамшуулал	36,915,741.00	61,672,013.91
210105	Гэрээт ажлын хөлс	35,784,335.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,513,434.60	158,228,056.46
210201	Тэтгэврийн даатгал	86,814,277.92	109,642,356.46
210202	Тэтгэмжийн даатгал	9,668,739.00	12,146,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,704,300.00	9,717,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,926,200.00	2,429,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,399,917.68	24,292,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	260,588,332.79	313,086,162.31
210301	Гэрэл, цахилгаан	10,299,832.79	12,739,962.31
210302	Түлш, халаалт	250,288,500.00	300,346,200.00
2105	Нормативт зардал	74,080,050.00	104,087,900.00
210502	Хоол, хүнс	74,080,050.00	104,087,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,567,000.00	17,000,000.00
210604	Урсгал засвар	3,567,000.00	17,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,328,200.00	12,783,933.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,985,700.00	2,226,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,342,500.00	10,557,333.52
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,705,174.20	60,592,945.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,130,474.20	44,129,245.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,574,700.00	16,463,700.00

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,090,528.12	135,435,811.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	129,734,634.00	129,465,274.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	86,545,500.00	84,432,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	43,189,134.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	45,033,274.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	5,970,537.69
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,970,537.69
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,355,894.12	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,355,894.12	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	66,289,624.86	355,197,289.63
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	28,222,110.00	57,977,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,222,110.00	57,977,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,222,110.00	57,977,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,222,110.00	57,977,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-28,222,110.00	-57,977,400.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	38,067,514.86	297,219,889.63
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	38,067,514.86
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	38,067,514.86	335,287,404.49

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2011 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	474,698,217.20	00.00	5,094,471,298.76	5,569,169,515.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	474,698,217.20	00.00	5,094,471,298.76	5,569,169,515.96
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C07	Тайлант үеийн үр дүн	40,130,000.00	00.00	1,028,298,023.19	-988,168,023.19
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	514,828,217.20	650,955,463.69	4,288,721,693.43	5,454,505,374.32
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	514,828,217.20	650,955,463.69	4,288,721,693.43	5,454,505,374.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	514,828,217.20	650,955,463.69	4,288,721,693.43	5,454,505,374.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн			253,237,817.08	253,237,817.08
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	514,828,217.20	650,955,463.69	4,541,959,510.51	5,707,743,191.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,336,913,700.00	2,112,471,170.96	224,442,529.04	90.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,336,913,700.00	2,112,471,171.00	224,442,529.00	90.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,191,692,200.00	1,983,005,897.00	208,686,303.00	90.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,436,071,400.00	1,259,249,499.20	176,821,900.80	87.7
210101	Үндсэн цалин	973,963,300.00	836,811,433.40	137,151,866.60	85.9
210102	Нэмэгдэл	400,997,200.00	360,766,051.80	40,231,148.20	90.0
210104	Урамшуулал	61,110,900.00	61,672,013.90	-561,113.90	100.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,509,000.00	158,228,056.50	21,280,943.50	88.1
210201	Тэтгэврийн даатгал	122,066,200.00	109,642,356.50	12,423,843.50	89.8
210202	Тэтгэмжийн даатгал	14,360,700.00	12,146,500.00	2,214,200.00	84.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,488,600.00	9,717,400.00	1,771,200.00	84.6
210204	Ажилгүйдлийн даатгал	2,872,100.00	2,429,000.00	443,100.00	84.6
210205	Эрүүл мэндийн даатгал	28,721,400.00	24,292,800.00	4,428,600.00	84.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	319,056,700.00	313,086,162.30	5,970,537.70	98.1
210301	Гэрэл, цахилгаан	13,746,500.00	12,739,962.30	1,006,537.70	92.7
210302	Түлш, халаалт	303,174,200.00	300,346,200.00	2,828,000.00	99.1
210303	Цэвэр, бохир ус	2,136,000.00	00.00	2,136,000.00	00.0

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	107,860,700.0	104,087,900.0	3,772,800.0	96.5
210502	Хоол, хүнс	107,860,700.0	104,087,900.0	3,772,800.0	96.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,000,000.0	17,000,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	17,000,000.0	17,000,000.0	00.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,239,000.0	12,783,933.5	455,066.5	96.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,258,600.0	2,226,600.0	32,000.0	98.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,980,400.0	10,557,333.5	423,066.5	96.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	118,955,400.0	118,570,345.5	385,054.5	99.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	102,484,800.0	102,106,645.5	378,154.5	99.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,470,600.0	16,463,700.0	6,900.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145,221,500.0	129,465,274.0	15,756,226.0	89.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	145,221,500.0	129,465,274.0	15,756,226.0	89.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	100,188,200.0	84,432,000.0	15,756,200.0	84.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,033,300.0	45,033,274.0	26.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,336,913,700.0	2,415,661,598.3	-78,747,898.3	103.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,944,063,100.0	1,944,063,100.0	00.0	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,944,063,100.0	1,944,063,100.0	00.0	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	336,056,700.0	336,056,700.0	00.0	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	336,056,700.0	336,056,700.0	00.0	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	56,793,900.0	135,541,798.3	-78,747,898.3	238.7
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,258,600.0	135,541,798.3	-133,283,198.3	6,001.1
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	54,535,300.0	00.0	54,535,300.0	00.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.0	38,067,514.9	-38,067,514.9	00.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.0	335,287,404.5	-335,287,404.5	00.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	73.0	73.0	00.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	56.00	56.00	0.00	100
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00	0.00	100
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	800.00	800.00	0.00	100

630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	800.00	800.00	0.00	100
630001	Төрийн өмчит ЕБС	800.00	800.00	0.00	100
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	74.00	74.00	0.00	100
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	56.00	56.00	0.00	100
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	01.00	01.00	0.00	100
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	01.00	01.00	0.00	100
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16.00	16.00	0.00	100

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, “Хүний хөгжлийг хангахуйц төрийн үйлчилгээний орчинг сайжруулж боловсролын үйлчилгээний чанар, үр өгөөжийг дээшлүүлэн, стандарт, хангалтыг дээшлүүлэх” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Тус байгууллага нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Сургалтын алба, үйлчилгээний алба гэсэн бүтэц зохион байгуулалттай 49 орон тоотой, 403 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянлиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны А/22 дугаар тушаалаар баталсан Боловсролын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг мөрдөж байгаа ба Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянлиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,507,993.0 мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	38,067.5	335,287.4	297,219.9
Авлага	23,701.8	-	-23,701.8
Бараа материал	125,182.3	150,044.7	24,862.4
Үндсэн хөрөнгө	6,449,937.6	6,507,993.0	58,055.4
хуримтлагдсан элэгдэл	(1,182,383.8)	(1,285,581.9)	-103,198.1
Нийт хөрөнгө	5,454,505.4	5,707,743.2	253,237.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,454,505.4	5,707,743.2	253,237.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,454,505.4	5,707,743.2	253,237.8

Эх сурвалж: Баянлиг сумын ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянлиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд оны эхэнд 38,067.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 335,287.4 мянган төгрөгийн өмнөх оноос 297,219.9 мянган төгрөгөөр өссөн

Гашуун дэлийн бага сургууль татан буугдаж тухайн сургуулийн үлдэгдлийг шилжүүлж авсан голлох нөлөөг үзүүлсэн байна.

Тайлан онд өмнөх оны авлагыг бүрэн барагдуулсан байна.

Бараа материалын данс Боловсрол Шинжлэх ухааны газраас 4,614.8 мянган төгрөгийн түрээсийн сурах бичиг, бага сургуулиас 2,571.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, данс хооронд 26,516.0 мянган төгрөгийн номыг шилжүүлэн бүртгэсэн, сургуулийн захирлын тушаалаар 33,399.6 мянган төгрөгийн бараа материалыг актлаж данснаас хасч бараа материалын үлдэгдэл өмнөх 24,862.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл нөхөн хангалт, болон гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллын зардлаас 78,207.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан, Боловсролын ерөнхий газраас 8,071.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, аймгийн ОНХС-аас 4035.1, сумын ОНХС-аас 49,051.0 мянга, сумын бага сургуулиас 21,655.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлж авсан, хөрөнгийн тооллогоор илэрсэн бүртгэлгүй байсан 3,393.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод авсантай холбоотой үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 13/08 тогтоолоор 79,842.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хөрөнгө актлаж данснаас хассан, 22,486.8 мянган төгрөгийн хөрөнгийг данс хооронд шилжүүлэн бүртгэсэн байна.

Өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 253,237.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, 5,707,743.1 мянган төгрөг болсон тайлант үеийн үр дүнгийн зардлаар нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,588,099.7 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас 587,242.7 мянган төгрөгөөр буурч 2,000,857.0 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тайлант онд төсөвт 4 удаа тодотгол хийж 444,900.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь багш ажилчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 1,944,063.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр 1,452,298.3 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 335,287.4 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Дансны үлдэгдлийг зардлаар нь үзвэл цалин , нийгмийн даатгал, дотуур байрны хоолны зардлын үдийн цайны үлдэгдэл эзэлж байгаад бөгөөд бага сургуулийн дансны 135,541.7 мянган төгрөг нийт үлдэгдлийн 40.4% ийг эзэлж байна.

Орон нутгийн төсвөөс анх батлагдсан төсөв 336,056.7 мянган төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 330,086,1 мянган төгрөгийг зарцуулж 5,970.5 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	4392.2	4392.2	0	100%
2	80312 Сургалт семинар	2263.6	1958.5	305.1	86.50%
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	4392.2	4350	42.2	99.00%
4	81801 Үдийн цай хөтөлбөр	100188.2	84432	15756.2	84.30%
5	81806 Дотуур байрны үйлчилгээ	160881.2	137218.47	23662.9	85.30%
6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	46012.8	45993	19.8	100.00%
7	81823 Боловсролын байгууллагын багш	10138.6	10138.5	0.85	100%
8	81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	16100.1	13099.5	3000.5	81.40%
9	81834 Боловсролын стандарт, сургалтын	1367109.6	1228929.9	138179.6	89.90%
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	287119.9	249646.4	37473.4	86.90%
11	81848 Сурах бичгийн түрээс	2258.6	2226.6	32	98.60%
12	80112 Нийтлэг үйлчилгээ	336056.7	330086.1	5970.5	98.20%
ДҮН		2336913.7	2112471.17	224442.5	90.40%

Эх сурвалж:2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд үдийн хоол хөтөлбөрт 100,188.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж 1 багц, дотуур байрны хүүхдийн хоол 107860.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж 1 багц тендерийг худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан нээлттэй тендер зарлан харьцуулалтын аргаар "Их халбагонт" ХХК-тай 2 багц тендерт орж гэрээ байгуулан гүйцэтгэлээр 188,519.9 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжүүлэх хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс ерөнхий гэрээ байгуулсан гүйцэтгэгчээс Хүүхдэд ээлтэй сургалтын орчин төсөл хөтөлбөрийн нөхөн хангалтын зардлаас 22,475.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч харин бусад хангамж бичиг хэргийн бараа материалыг шууд худалдан авалтын аргаар худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянлиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар

сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн захирал Г.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянлиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал С.Цэдэндорж, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Нарангэрэл нар зурсан байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 зугаар улирлын нийт зардлын 1,440,075.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,400.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 10,800.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,239,958.3 мянган төгрөгийн 60 гүйлгээ, зарлагын 1,480,894.9 мянган төгрөгийн 29 гүйлгээ өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 38 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн. Хугацаандаа мэдээлсэн 154, хугацаа нь болоогүй 16, хугацаа хоцорсон 1 мэдээлэл байгаа нь шатны байгууллагаас төсөв хугацаандаа ирээтэй холбоотой гарсан болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, 2,325.2 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, зөрчил арилгах 1 албан шаардлага, 7,230.1 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	2325.2	3	2325.2	100.00%
Албан шаардлага	1	0	1	0	100.00%
Зөвлөмж	2	7,230.10	2	7230.1	100.00%
Нийт дүн	6	9555.3	6	9555.3	100.00%

Эх сурвалж: Баянлиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023.05.24-ны өдрийн 58 дугаар албан бичиг

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2023.05.24-ны өдөр 58 дугаар албан бичгээр ирүүлсэн, төлбөрийн акт, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллажээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,050.0 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрсэнд төлбөрийн акт, тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

1.Илрүүлэлт: Өмнөх оны аудитаар зөвлөмжийн хэрэгжүүлээгүй, 1,050.0 малыг нас дэвшилт хийж бүртгээгүй, тооллогын комисс малыг нүд үзэж тоолоогүй байхад актлах шийдвэр гаргаж данснаас хассан байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дэх “Төрийн өмчийн хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хуульд заасан хугацаанд болон зайлшгүй шаардлагатай үед хийнэ” 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалттай нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

1. Шийдвэрлэсэн нь: Бараа материалын үлдэгдэлд байсан малыг үндэслэлгүй акталж данснаас хассан 1,050.0 мянган төгрөгийг төсвийн шууд захирагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Хүснэгт 6. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил								
Өмнөх оны аудитаар зөвлөмжийн хэрэгжүүлээгүй, 1,050.0 малыг нас дэвшилт хийж бүртгээгүй, тооллогын комисс малыг нүд үзэж тоолоогүй байхад актлах шийдвэр гаргаж данснаас хассан.	1	1,050.0	1	1,050.0				
Нийт дүн	1	1,050.0	1	1,050.0				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo--





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 56/14210513/БНА/2024
/101/НА-СТА-Т/243

Номгон

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянлиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст бараа материалын дансанд бүртгэлтэй байсан 1,050,000 төгрөгийн малыг анхан шатны баримтын бүрдэлгүй данснаас хассан, өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дэх "Төрийн өмчийн хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хуульд заасан хугацаанд болон зайлшгүй шаардлагатай үед хийнэ" 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалттай нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.7 дахь "Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**


1. Бараа материалын үлдэгдэлд байсан малыг анхан шатны баримтын

5050112

бүрдэлгүй данснаас хассан 1,050,000.00 /Нэг сая тавин мянган/ төгрөгийг төсвийн шууд захирагчаар төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.


2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ирүүлэхийг Баянлиг сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Цэдэндорж, нягтлан бодогч Б.Нарангэрэл нарт хариуцуулав¹.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН

АУДИТОР:



О.МАНДАХ

041703544
01740007 3007423

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн зрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно